


МӨНГӨНИЙ ТОЙМ

/2014 оны 9 дүгээр сар/



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014									
	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар
Инфляци										
Улаанбаатар хотын инфляци										
сарын	1.7	1.7	1.0	0.5	0.8	1.3	0.5	0.6	0.7	1.0
оны эхнээс	11.2	1.7	2.8	3.3	4.1	5.5	6.0	6.6	7.4	8.5
жилийн	11.2	12.2	12.0	11.9	12.0	13.9	15.1	15.4	13.6	13.6
Суурь инфляци										
сарын	1.3	0.7	0.3	0.2	0.7	0.8	0.6	2.2	2.4	1.3
оны эхнээс	12.1	0.7	1.0	1.2	1.9	2.7	3.3	5.6	8.1	9.6
жилийн	12.1	12.6	13.1	12.6	13.1	14.8	15.8	17.9	15.6	15.5
Улсын инфляци										
сарын	0.7	1.7	0.9	0.8	1.0	1.5	0.5	0.4	0.4	0.7
оны эхнээс	11.9	1.7	2.7	3.5	4.6	6.2	6.7	7.2	7.7	8.5
жилийн	11.9	12.3	12.2	12.4	12.3	13.7	14.6	14.9	13.7	13.0
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр	9 454.9	10 021.9	9 847.8	9 949.4	10 203.3	10 240.5	10 107.0	10 078.2	10 136.0	10 070.6
сарын өөрчлөлт, %	3.9	6.0	-1.7	1.0	2.6	0.4	-1.3	-0.3	0.6	-0.6
жилийн өөрчлөлт, %	24.2	36.5	36.1	36.3	42.0	29.5	26.3	24.6	20.5	18.7
Бараг мөнгө, тэрбум төгрөгөөр	7 361.7	8 058.7	8 092.6	8 212.1	8 357.6	8 414.2	8 244.9	8 379.8	8 261.3	8 234.3
сарын өөрчлөлт, %	1.2	9.5	0.4	1.5	1.8	0.7	-2.0	1.6	-1.4	-0.3
жилийн өөрчлөлт, %	27.4	39.9	40.6	43.8	51.5	37.3	37.9	36.0	27.9	27.4
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр	841.1	894.3	756.6	801.2	841.6	863.0	860.0	859.6	880.1	827.3
сарын өөрчлөлт, %	4.6	6.3	-15.4	5.9	5.0	2.5	-0.3	-0.1	2.4	-6.0
жилийн өөрчлөлт, %	1.5	20.5	12.0	16.5	10.8	3.9	2.9	3.3	1.4	-5.4
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр	3 335.5	2 957.4	3 131.1	3 127.5	2 598.8	3 007.8	2 882.2	2 905.1	2 814.8	2 826.5
сарын өөрчлөлт, %	18.1	-11.3	5.9	-0.1	-16.9	15.7	-4.2	0.8	-3.1	0.4
жилийн өөрчлөлт, %	54.0	36.6	37.9	26.7	4.0	7.4	-17.9	-6.4	8.2	-4.0
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	10 764.2	11 009.8	11 153.9	11 380.9	11 737.7	12 064.9	12 302.1	12 225.4	12 338.4	12 611.5
сарын өөрчлөлт, %	-0.5	2.3	1.3	2.0	3.1	2.8	2.0	-0.6	0.9	2.2
жилийн өөрчлөлт, %	54.0	54.2	55.6	54.0	51.0	46.7	42.9	34.1	26.1	24.2
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар	5.26	5.28	5.36	5.22	5.25	5.14	4.61	4.92	5.02	4.68
Чанаргүй зээл/Нийт зээл, хувиар (Хадгаламж, Анод, Зоос-ыг хассанаар)	2.48	2.56	2.65	2.57	2.68	2.68	2.72	3.00	3.16	2.84
Хүү										
Хадгаламжийн ЖДХ	12.1	12.2	12.2	12.2	12.2	12.2	12.2	12.2	12.2	12.3
Зээлийн ЖДХ*	17.4	18.9	18.4	19.7	19.4	19.1	18.8	19.2	19.6	18.3
Монголбанкны ҮТХ зээлийг оруулсан ЖДХ*	14.9	17.0	16.4	17.8	17.6	17.2	17.3	17.5	17.6	16.3
Ипотекийн зээлийн ЖДХ	9.90	9.79	9.90	9.90	9.80	10.0	10.5	10.7	10.5	10.6
ТБҮЦ-ны ЖДХ	10.5	10.5	10.6	10.6	10.6	10.6	10.6	10.6	11.8	12.1
Бодлогын хүү	10.5	10.5	10.5	10.5	10.5	10.5	10.5	12.0	12.0	12.0
БХЗ-ын ЖДХ	8.9	9.5	9.8	9.4	9.6	10.3	10.4	10.8	12.4	12.4

* Төсвийн зээлийн жилнээс дундаж хүү

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 9 дүгээр сарын эцэст өмнөх сараас 0.7 хувь, оны эхнээс 8.5 хувь, өмнөх оны мөн үеэс 13.0 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 1.0 хувь, оны эхнээс 8.5 хувь, өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар тус тус өслөө. Суурь инфляци сарын 1.3 хувь, оны эхнээс 9.6 хувь, жилийн 15.5 хувь байв.

Тухайн сард мах, махан бүтээгдэхүүн 1.2 хувь, хүнсний ногоо 1.2 хувь, өндөг 1.4 хувиар буурсан бол талх, гурил, будааны үнэ 1.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 4.1 хувиар өссөн нь хүнсний барааны бүлгийн үнэ 0.2 хувиар өсөхөд нөлөөлсөн байна. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 1.4 хувиар өссөн бөгөөд хувцас, бөс бараа 1.1 хувь, нэг шуудай нүүрсний үнэ 33.3 хувиар өсчээ. Харин өрхийн халуун усны үнэ 18.5 хувиар буурсан байна.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 64 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 12 бараа үйлчилгээнийх буурсан байна.



Жилийн инфляцийн 25.9 хувийг хүнсний бараа, согтууруулах бус ундаа, 74.1 хувийг хүнснээс бусад барааны бүлгийн үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 16.4 хувь (жилийн өсөлтийн 15.4 хувь), орон сууц, ус, цахилгаан, түлш 19.5 хувь (жилийн өсөлтийн 19 хувь), боловсрол 17.7 хувь (жилийн өсөлтийн 9.6 хувь), тээвэр 10.4 хувь (жилийн өсөлтийн 8.9 хувь), согтууруулах ундаа, тамхи 12.5 хувь (жилийн өсөлтийн 4.3 хувь), гэр ахуйн тавилга, бараа 15.5 хувь (жилийн өсөлтийн 3.7 хувь), эм тариа эмнэлгийн үйлчилгээ 14.7 хувь (жилийн өсөлтийн 3.2 хувь), зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 11.4 хувь (жилийн өсөлтийн 3.1 хувь), бусад бараа үйлчилгээний бүлэг 19.9 хувиар (жилийн өсөлтийн 5.1 хувь) тус тус өссөн байна. Хүнсний барааны бүлгийн жилийн өсөлтийн 52.8 хувийг талх, гурилан бүтээгдэхүүн, 6.4 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 19.9 хувийг өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн, 7.0 хувийг хүнсний ногооны үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлт


Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 0.6 хувиар буурч, оны эхнээс 6.5 хувь, өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өсч 10070.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн 51.8 хувийг төгрөгийн хадгаламж, 17.4 хувийг валютын хадгаламж, 12.9 хувийг төгрөгийн харилцах, 12.5 хувийг валютын харилцах, 5.3 хувийг

хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.



Ипотекийн хөтөлбөрийг мөнгөний нийлүүлэлтээс хасч тооцвол мөнгөний нийлүүлэлт 16.1-18.7 хувиар өсөхөөр байв.



Тайлант сард гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 33.1 нэгж хувиар өссөн бол, төгрөгийн хадгаламжийнх 9.5 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 8.1 нэгж хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 7.9 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 3.8 нэгж хувиар буурсан байна.

Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж

231.9 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 79.8 тэрбум төгрөг, гадаад валютын харилцах 33.1 тэрбум төгрөгөөр буурсан бол, гадаад валютын хадгаламж 238.0 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 41.5 тэрбум төгрөгөөр өсчээ.



Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 71.2 хувийг төгрөгийн хадгаламж, 32.5 хувийг гадаад валютын хадгаламж, 7.7 хувийг гадаад валютын харилцах, -7.5 хувийг төгрөгийн харилцах, -3.9 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 0.1 хувь буюу 6.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 30.9 хувь буюу 1646.9 тэрбум төгрөгөөр өсч 6970.5 тэрбум төгрөг болов.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 13.1 хувь буюу 245.3 тэрбум төгрөгөөр буурч, харин өнгөрсөн оны мөн үеэс 2.4 дахин их буюу 952.8 тэрбум төгрөгөөр өсч 1630.7 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.4 хувь буюу 13.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 5.2 хувь буюу 177.8 тэрбум төгрөгөөр өсч 3584.4 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сараас 15.7 хувь буюу 238.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 41.7 хувь буюу 516.3 тэрбум төгрөгөөр өсч 1755.4 тэрбум төгрөг болжээ.



Нийт хадгаламжийн 74.8 хувь нь төгрөгийн, 25.2 хувь нь валютын хадгаламж байгаа бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгж хувиар буурсан байна.

Гадаад, дотоод цэвэр актив


Гадаад цэвэр актив өмнөх сараас 7.8 хувиар өсч өмнөх оны мөн үеэс 150.2 хувиар буурснаар -972.1 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сараас өөрчлөлт багатай, өмнөх оны мөн үеэс 68.4 хувиар өсч 11042.7 тэрбум төгрөг болов.



Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 0.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар буурч 2826.5 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 13.0 хувь буюу 79.8 тэрбум төгрөгөөр буурсан бол Төв банк дахь харилцах, хадгаламж 3.3 хувь буюу 64.5 тэрбум төгрөг,

банкуудын касс 10.3 хувь буюу 27 тэрбум төгрөгөөр өссөн байна.




Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өсч 70.8 хувь, банкуудын кассын эзлэх хувь 0.8 нэгж хувиар өсч 10.2 хувь, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгөнийх 1.3 нэгж хувиар буурч 19.0 хувь болсон байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд саарч өмнөх сараас 1.9 нэгж хувиар буурчээ.

Хадгаламжийн байгууллагуудаас ¹ олгосон зээл өмнөх сарынхаас 2.2 хувь буюу 273.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 24.2 хувь буюу 2458.1 тэрбум төгрөгөөр өсч 12.6 их наяд төгрөгт хүрсэн байна. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 2.0 хувь

буюу 127.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 21.3 хувь буюу 1172.6 тэрбум төгрөгөөр өсч 6681.5 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 2.1 хувь буюу 117.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 26.5 хувь буюу 1211.3 тэрбум төгрөгөөр өсч 5778.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Харин 8%-ийн ипотекийн зээлийг хасч тооцвол, иргэдийн зээлийн жилийн өсөлт 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 23.0 хувьтай байхаар байжээ.

Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 53.0 хувь нь хувийн хэвшил, 45.8 хувь нь иргэд, 1.1 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

¹Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө

татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.




Нийт зээлийн үлдэгдлийн 91.6 хувийг хэвийн зээл, 3.7 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.7 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.6 нэгж хувиар буурсан байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол нийт зээлд эзлэх чанаргүй зээл 2.8 хувьтай байна.

Картын зээл

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.2 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл тайлант сард 277.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар буюу 38.1 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон байгаа бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 1 хувиар буюу 2.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

² Банкуудын тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулахгүй тооцсон хүү болно. Харин ҮТХ-ийн зээлийг оруулан тооцвол



Картын зээлийн 94.8 хувь нь хэвийн, 2.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.9 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 95.1 хувь нь төгрөгөөр, 4.9 хувь нь валютаар олгогдсон байна

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2014 оны 9 дүгээр сард өнгөрсөн оны мөн үеэс 1.6 нэгж хувиар өсч жилийн 12.08 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч жилийн 18.3² хувь, гадаад валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.7 нэгж хувиар өсч жилийн 13.8 хувь болжээ.


төгрөгийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 16.3 хувь байна.



Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 2.6 хувь, валютынх жилийн 1.7 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 12.3 хувь, валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 5.5 хувь болов.

Мөнгөний зах

2014 оны 9 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 999.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.41 хувь байна.



2014 оны 9 сарын 3-ны өдрөөс 9 сарын 30-ны өдрийн хугацаанд банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 896.6 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 406.9 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 900.0 тэрбум төгрөг, валютын нөөцөд 1085.2 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2014 оны 9 дүгээр сарын эцэст 1840.91 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 194.4 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1835.75 төгрөг байв.

